

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2021 оны 06 дугаар сарын 07-ний өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Мэдрэгчид суурилсан ялгагч төхөөрөмж нийлүүлэх**  
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/202112441**

**“Монголросцветмет” ТӨҮГ** эрх бүхий тендерт оролцогчдоос **“Мэдрэгчид суурилсан ялгагч төхөөрөмж нийлүүлэх”** тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Сүүлийн 2 жилийн аль нэгний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө эсвэл авах боломжтой зээлийн хэмжээ тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 50 хувиас багагүй байна.**

Тендерийн хамт **67,500,000** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 09:00 цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 09:10 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичгийн талаарх болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98,  
305 тоот өрөө, утас: 450060 + 138

**“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ**